



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 4/103

Булган сум

“Таван аваргын нэрэмжит барилдаан”-ыг ТВ9 телевизээр шууд дамжуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийг иргэд олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд сар шинийн баярыг тохиолдуулан зохион байгуулж буй “Таван аваргын нэрэмжит барилдаан”-ыг ТВ9 телевизээр шууд дамжуулах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Шууд нэвтрүүлгийн зардалд шаардагдах 4,020,000 (дөрвөн сая хорин мянга) төгрөгийг Аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 18-ны/ний өдрийн 1103 дүгээр
захирамжийн хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

д/д	Зардлын зориулалт	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	2	3	
1	ТВ9 телевизийн багийг байрлуулах буудлын зардал	11 хүн 2 хоног	1,300,000
2	Хоолны зардал	11 хүн 2 хоног	1,320,000
3	Шатахууны зардал	340л /2 машин/	1,100,000
4	Бусад зардал		300,000
	Нийт		4,020,000